

**“ТӨВЧАНДМАНЬ ДЭХГ” ОНӨААТҮГ-ЫН “УС
ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГА, ДУЛААН
ХАНГАМЖИЙН БАЙГУУЛАМЖ”-ИЙН 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ГАРЧИГ

1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1.ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	4
1.2.ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, ТЕХНИК ТЕХНОЛОГИ	6
2.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	8
2.1.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	9
2.2.ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	27
2.3. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	28
2.4.ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	33
2.5.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	40
2.6.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	40
2.7.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	55
2.8.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	56



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	9
Хүснэгт 2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт.....	27
Хүснэгт 3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	28
Хүснэгт 4. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	33
Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	40
Хүснэгт 6. Төслийн талбайн 1-р зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл	43
Хүснэгт 7. Төслийн талбайн 1-р зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт	43
Хүснэгт 8. Төслийн талбайн 2-р зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл	44
Хүснэгт 9. Төслийн талбайн 2-р зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт	44
Хүснэгт 10. Төслийн талбайн 3-р зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл	45
Хүснэгт 11. Төслийн талбайн 3-р зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт	45
Хүснэгт 12. Хөрсний механик бүрэлдэхүүн.....	46
Хүснэгт 13. Хөрсөн дэх хүнд металлын үзүүлэлтүүд, 2020 он.....	46
Хүснэгт 14. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ	47
Хүснэгт 15. Бохир усны шинжилгээ	51
Хүснэгт 16. Цэвэр усны химийн ерөнхий шинжилгээ	51
Хүснэгт 17. Цэвэр усны бичил амьсудлалын шинжилгээ.....	52
Хүснэгт 18. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн, мг/м ³	54
Хүснэгт 19. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	55
Хүснэгт 20. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	56

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ус хангамж, ариутгах татуургын байгууламжууд байршлын зураг	5
Зураг 2. Халаалтын зуухнуудын байршил зураг.....	5
Зураг 3. Цэвэр ус хангамжийн байгууламжуудын байрлал.....	6
Зураг 4. Цэвэрлэх байгууламжийн байршил	7
Зураг 5. Сургалт зохион байгуулж байгаа байдал.....	32
Зураг 6. Хөрсний дээж авсан цэгүүдийн зураг.....	49
Зураг 7. Уснаас дээж авч буй байдал	50
Зураг 8. Агаарын хэмжилт хийж байгаа зураг.....	53



1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:

- Ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн байгууламж”

Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

- “Төвчандмань ДЭХГ” ОНӨААТҮГ
 - Улсын бүртгэлийн дугаар: 1414001001
 - Регистрийн дугаар: 3855562

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

- Төв аймаг, Зуунмод сум, 1-р баг, өөрийн байр.
- Утас: (+976) 70273894

Төслийн хүчин чадал

- Дулаан хангамжийн 9 халаалтын хэсэгт нийт 35 усан халаалтын зуух ажиллан, 1000 мян.м³ эзэлхүүнтэй барилга, байгууламжийг дулаанаар хангаж байна.

Төслийн байршил:

Төв аймгийн Зуунмод сум нь Улаанбаатар хотоос зүүн урагш 45 км-т оршино.

"Төв Чандмань" ДЭХГ нь Зуунмод сумын хүн амыг хэрэглээний цэвэр усаар хангах, бохир усыг татан, цэвэрлэх, дулаанаар хангах үйлчилгээг үзүүлдэг, орон нутгийн өмчит нийтийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар юм.


Ус хангамжийн эх үүсвэр болох гүний худгууд нь аймгийн төвөөс урагш ойролцоогоор 15 км орчим зайтай хөшигийн хөндийд, бусад эх үүсвэр нь аймгийн төвийн суурьшлын бүс дотроо, цэвэрлэх байгууламж нь төвөөс урагш 2.5 км-т байрладаг.

Ариутгах татуургын систем нь аймгийн төвийн хэрэглэгчээ гарсан бохир усыг төвлөрсөн сүлжээгээр цуглуулж, цэвэрлэх байгууламжид цэвэрлэн, шүүрүүлэх талбайд нийлүүлдэг. Цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний чанар, технологийн горим хэвийн ажиллагаатай, дотоод хяналтын лабораторид тогтмол хяналт тавьдаг. Цэвэрлэх байгууламж нь аймгийн төвийн баруун урд талд байдаг.


Дулаан хангамжийн 9 халаалтын хэсэгт нийт 35 усан халаалтын зуух ажиллан нийт 1000 мян.м³ эзлэхүүнтэй барилга, байгууламжийг дулаанаар хангаж байна.

Усны эх үүсвэр, цэвэрлэх байгууламж, дулаан хангамжийн хэсгүүдийн байршлыг доорх зурагт харууллаа.





Зураг 1. Ус хангамж, ариутгах татуургын байгууламжууд байршлын зураг



Зураг 2. Халаалтын зуухнуудын байршил зураг

1.2.Төслийн хүчин чадал, техник технологи

Ус хангамж

Хөшигийн хөндийд байрлах төвлөрсөн системд холбогдсон усны эх үүсвэрийн 5 худаг, аймгийн төвд байрлах гүний 2 өрөмдмөл худаг, ус зөөврийн 1 машинтай.



Зураг 3. Цэвэр ус хангамжийн байгууламжуудын байрлал

Мөн ус хангамжийн систем нь 2 өргөх станц, 2 нөөцийн резервуар, 23 ус түгээх байртай. 2022 онд 4000 м3 багтаамжтай нөөцийн санг ашиглалтад оруулсан.

Зуунмод сумын 7000 орчим айл өрх, (орон сууц, гэр хороолол) 75 төсөвт байгууллага, 138 аж ахуйн нэгжийг цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах, хэрэглэгчдийг дулаан болон хэрэглээний халуун усаар хангадаг.

Ариутгах татуургын систем

Зуунмод сумын хүн ам, аж ахуйн газруудын бохир усыг баруун зүүн хоёр жигүүрээр цуглуулан цэвэрлэх байгууламжид хүргэдэг. Бохир ус нийлүүлэх том хэмжээний үйлдвэр байхгүй, ихэнхдээ ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжид нийлүүлэгдэнэ. Ажлын хувцасны үйлдвэр ажиллаж байгаад зогссон. Бохир ус дамжуулах хоолойн голч 150-400 мм, бохир ус өөрийн урсгалаар цэвэрлэх байгууламжид хүрдэг байна.

Зуунмод сумын цэвэрлэх байгууламж 1994 онд байгуулагдан ажиллаж эхэлсэн, 2010-2011 онд техник технологийн шинэчлэл хийгдсэн. Эзлэх талбай 27607 м², аймгийн төвийн баруун урд талд байрлана.

Хэрэглэгчээс ирсэн бохир усыг 90% хүртэл цэвэрлэн байгаль орчинд сөрөг нөлөөгүй хаягдал усыг зайлуулж байна. Цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний чанарт дүгнэлт гарган стандартын дагуу бохир усыг цэвэрлэхийн тулд хими, физик, гидробиологийн шинжилгээг дотоод хяналтын лабораторид стандартын дагуу гүйцэтгэн бохир усны цэвэрлэгээний түвшнийг 85-90% цэвэршүүлэн ф 400 мм-ын 8 км урт шугамаар Бор үзүүрийн хоёр картаар дамжуулан байгальд хаяж байна.

Цэвэрлэх байгууламж нь хо ногт 2700 м³ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай бөгөөд бохир усыг механик, биологийн аргаар цэвэрлэнэ. Байгууламж нь сараалжийн барилга, элс баригч, 2 секц бүхий блок байгууламжтай түүний бүрэлдэхүүнд анхдагч тунгаагуур, аэротенк, хоёрдогч тунгаагуур, контактын сан багтдаг. Бохир усыг гүн цэвэрлэх зорилгоор биоцөөрөм ашигладаг. Лаг тунадсыг эрдэсжүүлэгчид боловсруулж, лагийн талбайд шахаж, лаг пресслэгчээр усгүйжүүлэн хатаадаг. Сараалжийн хаягдал болон лагийг хлорын шохойгоор ариутгал хийн талбайдаа хадгалж байна.



Зураг 4. Цэвэрлэх байгууламжийн байршил

2.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Төвчандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын “Ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн байгууламж”-ийн 2023 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь уг төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулах бүхий л үе шатыг хамрах ба гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах арга хэмжээ буюу төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэхэд оршино.

Төв аймгийн Зуунмод сумын нутагт орших “Төвчандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын “Ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн байгууламж”-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан БОМТөлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, 2014 оны А-117 тоот тушаалын 4-р хавсралтаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг тус тус баримтлан боловсруулсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө, осол эрсдлийн менежмент, хог хаягдлын менежмент, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах зэрэг төлөвлөгөөнүүд багтсан. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд 10 205 000 төг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримтлах арга зүй, стандарт, холбогдох эрх зүйн баримт бичгийн заалт, зардлын задаргааг тусгасан.

2.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ТАЛААР		
Тоног төхөөрөмжийн ажиллагаа доголдож, халаалт тасрах	Халаалтын хэсгүүдийн засвар үйлчилгээг хийж, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангана.	Халаалтын хэсгүүдэд насос, сэнс болон тоног төхөөрөмжийн угсралтын ажил хийгдэж бүрэн дууссан. Халаалтын хэсгүүдэд 94 ширхэг хаалт, зөөлөн холбоо,үл буцах клапан суурилуулсан.
	Агаарын чанарын хяналт шинжилгээ хийх	Төвчандмань ДЭХГ-ын харьяа уурын зуухнуудын орчноос 9 цэгээс 2 үзүүлэлтээр агаараас хэмжилтийг хийж үнэлгээний дүнг гаргалаа. Орчны хяналт шинжилгээний хэсэгт дэлгэрэнгүй тусгав.
ГАЗАР ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ		



Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ		
Бохир ус алдагдаж, хөрс бохирдох	Бохир усны шугам сүлжээний төлөвлөгөөт засвар үйлчилгээг хийнэ	Цэвэр ус болон ариутгах татуургын шугам сүлжээний шинэчлэлийн ажлууд <u>Ариутгах татуургын шугам сүлжээний шинэчлэлийн ажлууд</u> - Шүүхийн шинжилгээний хэлтэс 44метр шугам болон 3 худаг шинээр суурилуулсан. 34-р байрны гадна бохирын 15метр шугам шинэчлэсэн. 10-р байрны гадна бохирын 20метр шугам шинэчлэсэн. 42-р байрны гадна бохирын 10метр шугам шинэчлэсэн. “Өгөөж сүмбэр” 6-р байрны подволын 35 метр шугам шинээр сольж суурилуулав.		
	Байгууллагын харьяаны объектуудад ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ.	Халдваргүйжүүлэлт хийж байгаа байдал.		 
	Хөрсний хяналт шинжилгээ хийх	Нийт 18 цэгээс хөрсний дээж авч, хөрсний агрохимийн 6 дээжийг 200-300 гр, хүнд металлын 15 дээжийг 200-300 гр хэмжээтэй авсан. Мөн хөрсний эрүүл ахуйн 15 дээжийг 100 гр хэмжээтэй авсан. Хөрсний агрохими, хүнд металл болон хөрсний эрүүл ахуйн дээжийг “Нарт Шуун Консалтинг” ХХК-ийн хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс харах		
УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР				
Усны алдагдал ихсэх	Шинэ нөөцийн сангийн ашиглалтын үйл ажиллагааг зүгшрүүлж ашиглалтад хүлээн авч усан хангамжийн	2023-2024 Өвалжилтын бэлтгэл ажлын хүрээнд УСОСАлба нь нийт 25 ажил төлөвлөсөн. 9 сарын 10-ны өдрийн байдлаар Цэвэр усны хэсэг-100%, Орон сууцны хэсэг-82%, Ариутгах татуургын хэсэг-92%, Ус түгээх байр -88.7% буюу нийт 23 ажил хийгдэж 90.6%-ийн биелэлттэй байна. Хяналтын худаг цэвэрлэх, засварлах, тагийг шинэчлэсэн		



Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
	үйлдвэрлэлийн үйл ажиллагааг найдвартай хангана. Цэвэр усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг сайжруулна.	✚ Хяналтын 3 ширхэг манометрийг суурилуулсан байдал ✚ 1-р эх үүсгэврийн 20 метр төмөр шугамыг хуванцар /HDPR/ болгох засварын ажил ✚ 3-р эх үүсгэвэрийн гүний сорох насос солих засварын ажил ✚ Цэвэр усны төв шугамын нийт 18 ширхэг гэмтэл засварлаж ажилласан. ✚ 42-р байрны гадна шугам сүлжээнд 8 метр, подвал буюу дотор талд нь 6 метр шугам сүлжээг шинэчлэх ажил хийгдсэн ✚ 10-р байрны бохирын 20 метр шугам сүлжээг шинэчлэх ажил ✚ 34-р байрны бохирын 15метр шугам шинэчлэх ажил хийгдсэн ✚ ШШАлбаны газрын 44 метр шугам шинэчлэх ажил хийгдсэн ✚ Ариутгах татуургын хяналтын нийт 24 худагт засвар үйлчилгээ хийгдсэн Цэвэр усны “HDPR” шугам сүлжээнд хийгдсэн засварын ажлууд • Цэвэр усны 11-12-р худгийн хооронд ф219 мм-ийн 150метр шугам шинэчилсэн. • Халаалтын 5-р хэсгийн урд ф125мм-ийн 24 метр шугам шинэчилсэн. • 1-р гүний худагт гаргалгааны ф100мм-ийн 24 метр шугам шинэчилсэн

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	
Цэвэр усыг зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн олдворлох	1,3-р өргөх станцад насосын шинэчлэл хийгдэнэ	3-р эх үүсгэврийн гүний сорох насос солих засварын ажил	
Усны нөөцийг зөвшөөрөлгүй ашиглах	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, гэрээ байгуулан ажиллана	“Төвчандмань ДЭХГ” ОНӨААТҮГ нь 2023 онд Усны газрын №32 дугаартай “Ус ашиглуулах дүгнэлт” гаргуулсан, мөн Туул голын сав газрын захиргааны даргын тушаал “Зөвшөөрөл олгох тухай” зэрэг бичиг баримтыг бүрдүүлэн ажиллаж байна. 	





“Тэрбум” мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд цэнгэлдэх хүрээлэнд 150 ширхэг улиас мод суулгав.



Мод тарьж байгаа байдал



ТӨЛБӨРИЙН БАРИМТ

Сонгогч сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт

ТӨЛБӨРИЙН БАРИМТ

№: 00000389155400020003000001501001

Бичлүүгч/хувиарч:

№: 3351554

№: МАРСТ-АР

Бич: Улаанбаатар, Төв, Аруус, 0, 0

ТН: 2558810, 08858810

Бичлүү: МАР

Бичлүү: Сонгогч сайдын дүрэм

Огноо: 2023-05-30

Хуудсанд ашиглагч:

ТН: 3455562

ТН: Төлөөлөгчийн ДЭХ

Хаяг: Мандал, Төв, Зуурагд, 0, сонгогч байршил

Утас: 99269255

№	Борлох, өмчлөх үйлчилгээний нэр	Код	Хэмжээний нэгж	Төл, хэмжээ	Нэгжний үнэ	Бүтэл үнэ
1	Мэдээлэл	33000	ш	1.00	880,000.00	880,000.00
	Борлох, өмчлөх үйлчилгээний үнэ:					880,000.00
	Нэмэгдсэн өртгийн албан татвар:				0.00	
	Мэдээлэл өртгийн албан татвар:				0.00	
	Нийт дүн:					880,000.00

Төлбөр


Хүлээн авсан (хэрим үсэг) _____ (хэрим)
Хүлээн авсан (хэрим үсэг) _____ (хэрим)

2023.05.30 - 1500 x 4400 = 660000

- ❖ Улиас модны суулгац худалдан авсан баримт

Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд дараах засвар үйлчилгээний ажил хийгдсэн.

✚ Хяналтын худаг цэвэрлэх, засварлах, тагийг шинэчлэсэн байдал



✚ 3-р өргөх станцын хлоржуулалтын 2 барилгын засварын ажил хийсэн байдал.



✚ Хяналтын 3 ширхэг манометрийг суурилуулсан байдал



✚ 1-р эх үүсгэврийн 20 метр төмөр шугамыг хуванцар /HDPR/ болгох засварын ажил



✚ 3-р эх үүсгэврийн гүний сорох насос солих засварын ажил



Цэвэр усны төв шугамын нийт 18 ширхэг гэмтэл засварлаж ажилласан.



42-р байрны гадна шугам сүлжээнд 8 метр, подвал буюу дотор талд нь 6 метр шугам сүлжээг шинэчлэх ажил хийгдсэн



10-р байрны бохирын 20 метр шугам сүлжээг шинэчлэх ажил



✚ 34-р байрны бохирын 15метр шугам шинэчлэх ажил хийгдсэн



ШШАлбаны газрын 44 метр шугам шинэчлэх ажил хийгдсэн



Ариутгах татуургын хяналтын нийт 24 худагт засвар үйлчилгээ хийгдсэн





✚ Цэвэрлэх байгууламжийн дээврийн засварын ажил



✚ Босоо конусан тунгаагуурын лагийг гномоор сорьж суллаж лагийн талбайд хаясан



Халаалтын улирлын өвөлжилтийн бэлтгэл ажил хангах хүрээнд тогоо болон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ болон халаалтын хэсгүүд тогоог шинэчлэн засвар үйлчилгээг хийснээр агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой.

2023-2024 ӨБАжлын хүрээнд ДЭХАлба нь нийт 61 ажил буюу 521,8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. 9 сарын 10-ны өдрийн байдлаар

- Халаалтын 1-р хэсэг -92%
- Халаалтын 2-р хэсэг-85%
- Халаалтын 3-р хэсэг-92%
- Халаалтын 4-р хэсэг -80%
- Халаалтын 5-р хэсэг -92%
- Халаалтын 6-р хэсэг – 94%
- Халаалтын 7-р хэсэг – 95%
- Халаалтын 9-р хэсэг 100%
- Халаалтын 10-р хэсэг -86% буюу нийт 55 ажил хийгдэж 90%-ийн биелэлттэй байна.

ӨБА хангах ажлын хүрээнд хийгдсэн ажлуудаас

- ❖ ДТХ-1.4 маркийн тогооны өрлөг болон хучилт хийсэн.



- ❖ ДТХ-1.4 маркийн тогооны арын панелейн засвар хийсэн.



- ❖ Халаалтын 6-р хэсэгт DZL-2.8 маркийн 2 тогооны ул ширэмний засварын ажил хийсэн.



- ❖ Халаалтын 5-р хэсэгт утааны явалтын түнелийг буулгаж шинээр хийсэн.



- ❖ Халаалтын 3-р хэсэгт КВР-3 маркийн 2 тогооны арын панелийг буулгаж, шинээр панель угсарч, тогооны гадна битүүмжлэлийг хийж дуусгасан.



- ❖ Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Халаалтын 3,10-р хэсгүүдэд DZW-4.2 маркийн 3 тогооны шинэчлэлтийн асуудлыг шийдэж өгснөөр дээвэр буулгах, хуучин тогоонуудыг авч, шинэ тогоо суурилуулах бэлтгэл ажлыг хангаад байна.



- ❖ Халаалтын 10-р хэсгээс DZL-2.8 маркийн 1 тогоог, Халаалтын 2-р хэсэгт шилжүүлэн суурилуулсан.



- ❖ Халаалтын 3-р хэсгээс КВР-3.0 маркийн 1 тогоог Халаалтын 4-р хэсэгт шилжүүлэн суурилуулсан.



- ❖ Халаалтын хэсгүүдэд насос, сэнс болон тоног төхөөрөмжийн угсралтын ажил хийгдэж бүрэн дууссан.



Халаалтын хэсгүүдэд 94 ширхэг хаалт, зөөлөн холбоо, үл буцах клапан суурилуулсан байдал

2.2.Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	
Орчны тохижилтийг сайжруулах	Өөрийн харьяаны зарим объектийн орчимд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Өөрийн харьяаны контор, цэвэрлэх байгууламж, халаалтын 2-р хэсгийн урд талбай зэрэг зарим объектийн орчимд ногоон байгууламжийг нэмэгдүүлж, арчилж тордон зүлэгжүүлсэн.	 
	Ногоон байгууламжийн арчилгаа хийх		 

2.3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө		Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	
БАЙГАЛИЙН АЮУЛ ГАМШИГ				
Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулдаг.		
ГАЛЫН АЮУЛ				
Галын аюул гарах	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, журам боловсруулж, түүнийг мөрдөн ажиллах	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, журам боловсруулж, түүнийг мөрдөн ажиллаж байна		
ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР				
Хөдөлмөрийн нөхцөл хангагдахгүй байх	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, хор саармагжуулах	Өдөр бүр Хөдөлмөрийн хамгаалал. аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажилладаг. - Ажилчид сар бүрийн хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр хангагдсан. - Хөдөлмөр хамгаалал, осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалтанд		



Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Хөдөлмөр хамгааллын аюулгүй байдал алдагдах	Хөдөлмөр хамгаалал, осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулах	хамруулсан. - Өдөр бүр Ажлын байран дахь давтан зааварчилгаатай танилцаж гарын үсэг зуран ажлаа эхлүүлж хэвшсэн. - Ажилчид 1-3 сарын хугацаанд хуваарийн дагуу ээлжинд гарсан. - Ажилчдын мэдээллийн самбарыг ажлын байрны тодорхойлолт, ээлжийн хуваарь, тушаал шийдвэр, журам, коронавирусын мэдээлэл зэргээр ханган ажиллаж байна. - Сургалт зохион байгуулж буй байдал. 
ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ		
Химийн бодисын ашиглалтын хяналт алдагдах	Лабораторийн химийн бодисын ашиглалт зарцуулалтын бүртгэл хөтөлж, ашиглалтад хяналт тавина	Лабораторийн зориулалттай химийн бодис урвалжийн хэрэглээг тогтмол бүртгэж, холбогдох байгууллагад тайлагнадаг.
	Химийн бодис, аюултай хог хаягдалтай харьцаж ажилладаг ажиллагсдыг үүсэж болох эрсдэлээс Урьдчилан сэргийлэх,	Химийн хорт болон аюултай бодисын хэрэглээ, хадгалалтын байдалд, химийн бодисын аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулах, хэрэгжилтэнд хяналт тавих, байгаль орчныг хамгаалах, бохирдлоос




Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Химийн бодис ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үед гарч болзошгүй эрсдэлүүд	түүнийг хянах, эрсдэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах мэдлэг, дадлыг эзэмшүүлэх, аюулгүй ажиллагааны сургалтад хамруулсан байх.	урьдчилан сэргийлэх талаар дотоодын хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг
	Химийн бодисыг хадгалах талбайд хадгалагдаж буй бодис тус бүр нь хаяг, тэмдэг тэмдэглэгээтэй байх ба тэдгээрийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж шаардлагатай нөхцөлд солино.	Урвалж бодисуудыг өөрийнх нь саванд зориулалтын хадгалах болон агааржуулалтын хоолойгоор тоноглогсон татах шүүгээнд хадгалдаг.
	Шаардлагатай үед хэрэглэх саармагжуулах бодисоор тогтмол хангах	Химийн бодис алдагдсан тохиолдолд саармагжуулах бодисыг лабораторид байршуулсан.
	Химийн бодис нь зориулалтын сав, баглаа боодол, стандартын шаардлага хангасан хаяг, шошготой болгох. сав баглаа, боодлын бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих	Химийн бодис өөрийнх нь саванд хадгалдаг, сав баглаа, боодлын бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж шалгадаг. Хэрэв сав баглаа, шошгоны бүрэн бүтэн байдал алдагсан байвал засаж янзалдаг.
	Химийн бодисын болзошгүй аюул, ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг холбогдох байгууллагаар батлуулан мөрдөж ажиллах	Химийн хорт болон аюултай бодис хадгалах зөвшөөрөл авахаар материалыг бүрдүүлэн өгсөн.
	Химийн бодисыг стандартын дагуу хадгалах, асгарах, алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Химийн хорт болон аюултай бодисын хэрэглээ, хадгалалтын байдалд, химийн бодисын аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулах, хэрэгжилтэнд хяналт тавих, байгаль орчныг хамгаалах, бохирдлоос урьдчилан сэргийлэх талаар дотоодын хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг

Хөдөлмөр хамгаалал, осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалтанд хамруулсан. Үүнд:

- “Хөдөлмөрийн болон ХАБЭА-н эрх зүйн орчин, Эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтнуудын тусгай сургалт зохион байгуулсан. Анхны тусламж гэж юу вэ? гэсэн сэдвийн хүрээнд 3 цагийн сургалтанд 63 ажилтан хамрагдсан.
- “Ажилчдын ажлын байрны эерэг соёлыг төлөвшүүлэх, ажлын байрны стресс бууруулах менежмент, ажил амьдралынхаа хэв маягт ямархуу өөрчлөлт хийх вэ” гэсэн сэдвийн хүрээнд 3 цагийн сургалтанд 180 ажилтан хамрагдсан.
- “Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н тухай хууль, дүрэм, журам, стандартын талаарх мэдлэг олгох бататгах” сургалтыг УСОСАлбаны Цэвэр усны хэсгийн ажилчдад зохион байгуулж 19 ажилтанд хамрагдсан.
- “Газар хөдлөлтийн гамшгийн аюул” сэдэвт танхимын сургалтанд 38 ажилтан хамрагдсан.
- “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Үйлдвэрийн осол гэмтлээс шалтгаалах өвчин”, Ажлын байрны эрсдлийн үнэлгээ гэсэн сэдэвт 3 цагийн сургалтанд 150 ажилтан хамрагдсан.





Зураг 5. Сургалт зохион байгуулж байгаа байдал

2.4.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 4. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
АХУЙН ХОГ ХАЯГДАЛ		
Ахуйн хэрэглээний хог хаягдал	Хог хаягдлыг ангилан ялгаж, эмх цэгцтэй хадгалах хогийн сав байршуулах.	Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж хийх савыг хаягжуулан хог хаягдал хадгалах түр цэгт байршуулсан.
	Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээвэрлэх болон үйлчилгээний гэрээ байгуулах	Хатуу хог хаягдлыг Зуунмод хотын нэгдсэн хогийн цэгт хаядаг бөгөөд хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээний дагуу тээвэрлэгч байгууллагад нийлүүлж, төлбөрийг төлдөг.
ҮЙЛДВЭРИЙН ХОГ ХАЯГДАЛ		
Үйл ажиллагаанаас гарах хог хаягдал	Сараалжийн хаягдлыг тусгай цэгт хуримтлуулж, төвлөрсөн хогийн цэгт зайлуулж, бүртгэл хөтөлнө.	Сараалжийн хаягдлыг аймгийн нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн зайлуулж. хог хаягдлыг тогтмол бүртгэдэг.
	Лагийн талбайд шахсан лагийн бүртгэл хөтөлнө	Хоёрдогч тунгаагчийн сувгийн лагийг цэвэрлэж лагийг лагийн талбайд хаясан
	Үнсний хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн зайлуулж, бүртгэл хөтөлнө.	Үнсний хаягдлыг аймгийн нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн зайлуулж, хог хаягдлыг тогтмол бүртгэдэг.
АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ		
	Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж	Лабораторийн шинжилгээнээс гарах химийн бодистой холимог уусмалын хаягдлыг хүчил, шүлтэнд тэсвэртэй саванд цуглуулан, саармагжуулан, бохирын шугамд нийлүүлнэ. Хог



Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Аюултай хог хаягдал ил задгай хаях	ахуйн нэгж, байгууллагатай хог хаягдал тээвэрлэх болон шилжүүлэх гэрээ байгуулах	хаягдлыг тогтмол бүртгэдэг.
	Аюултай хог хаягдлын сав баглаа боодлын (химийн бодсын сав, материал) бүрэн бүтэн байдалт хяналт тавих, бүртгэл хөтлөх, үлдэгдэл хаягдал асгарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Химийн бодсын сав, материалын бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж хянаж байгаа болно. Лабораторийн шинжилгээнээс гарах химийн бодистой холимог уусмалын хаягдлыг хүчил, шүлтэнд тэсвэртэй саванд цуглуулан, саармагжуулан, бохирын шугаманд нийлүүлнэ. Хог хаягдлыг тогтмол бүртгэдэг.

Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр дараах засвар үйлчилгээний ажил хийгдэв.

- Хоёрдогч тунгаагчийн сувгийн лагийг цэвэрлэж лагийг лагийн талбайд хаясан.



- ЦБ-н Сараалжийн хог шүүгч гагнаж хэвийн болгосон.



- Вентүрийн сувгийн лагийг цэвэрлэж лагийн талбай руу хаясан.




- Зүүндэлгэрийн цэвэрлэх байгууламжид засвар үйлчилгээ хийсэн.



Орон сууцны хэсэгт

- 46-р байрны дулааны өгөх буцах шугамын ф100 2 ширхэг гадна хаалт шинэчилсэн.
- 3-р байрны цэвэр ус болон дулааны ф50 мм гадна хаалт сольсон.



- Ардчилсан намын байрны урд худагт дулааны өгөх, буцах шугамын ф89мм-ийн 2 ширхэг хаалт шинэчилсэн.



- 28-р байрны 3-р орцны подвалын 8 метр ариутгах татуургын шугамыг шинэчилсэн.



Төлөвлөгөөнд тусгагдаагүй хийгдсэн ажлууд

- Өгөөж Сүмбэр 7-р байрны ХХУс болон цэвэр усны 32м шугам солисон.



- Өгөөж сүмбэр 6-р байрны Хэрэглээний халуун усны 12 метр шугам шинэчлэх ажил хийгдсэн



- 16-р байрны анхны худгаас оруулга хүртлэх дулааны өгөх буцах, цэвэр ус, Хэрэглээний халуун усны өгөх буцах 40 метр шугамыг шинэчлэх ажил хийгдсэн.



- 11-р байрны оруулга хүртэлх 6 метр дулааны өгөх шугамыг шинэчилсэн.



- 46-р байранд цэвэр усны ф89 хаалт суурилуулав.



2.5.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

“Төвчандмань ДЭХГ ОНӨАТҮГ-ын харьяаны объектууд аймгийн төвийн суурьшлын бүсэд байрлах тул түүх соёлын дурсгалд үзүүлэх нөлөөлөл байхгүй, мөн Хөшгийн хөндийд байрлах усны эх үүсвэрийн энгийн болон онцгой хамгаалалтын бүс, тэжээгдлийн мужид соёлын өвийн дурсгал байхгүй.

2.6.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд байгаль орчны хяналт шинжилгээний ажлын тайланг “Төвчандмань дэхг” ОНӨААТҮГ -тай байгуулсан гэрээний дагуу “Ашид-Ананда” ХХК боловсруулав. Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын тайланг хавсралтаар хавсаргав.

Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян. төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын чанар						
- SO2 - NO2 Тоос нийт (PM10, PM2.5)	Халаалтын 9 хэсгээс сонгоно	Жилд 1 удаа	9 цэгт 1 удаа	55.0 төг*1удаа*9цэг	4 950.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага. MNS 6063 : 2010 Агаарын чанар - Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 5885 : 2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
Хөрс						
Физик-химийн үзүүлэлт	Хөшигийн хөндийн эх үүсвэрийн хэсэг, насос станц, цэвэрлэх байгууламж	Жилд 2 удаа	3 цэг 2удаа	25.0 төг*2удаа*3 цэг	150.0	MNS 3298 : 1991 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис,



Хөрсний хүнд металлууд	Халаалтын 6 хэсэг Цэвэрлэх байгууламж УТБ-17 Өндрийн сан Насос станц	Жилд 2 удаа	10 цэг 2 удаа	84.0төг*2удаа* 10цэг	1 680.0	элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 3985 : 1987 Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтүүдийн нэр төрөл. MNS 2305 : 1995 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам. MNS 3297:2019 Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
Микробиологийн үзүүлэлт	Цэвэрлэх байгууламж УТБ-17 Өндрийн сан Насос станц	Жилд 2 удаа	20 цэг 2 удаа	45.0 төг*2удаа*20 цэг	1 800.0	
Усны чанар						
Химийн найрлага	УТБ Эх үүсвэр Өндрийн сан Насос станц	Сар бүр (12 удаа)	5 цэгт 12 удаа	25.0 төг*12удаа*5цэг	1 500.0	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус.
Эрүүл ахуйн үзүүлэлт	УТБ Эх үүсвэр Өндрийн сан Насос станц	Сар бүр (12 удаа)	5 цэгт 12 удаа	48.0 төг*12удаа*5цэг	2 880.0	MNS 5667:10:2001 Байгаль орчин. Хаягдал уснаас дээжлэлт хийх удирдамж MNS ISO 5667-11 : 2000 Усны чанар. Гүний уснаас дээж авах зөвлөмж MNS 4586 : 1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага NS 0899 : 2020 Унд ахуйн зориулалттай төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийг сонгох журам ба эрүүл ахуй, техникийн шаардлага MNS 3342 : 1982 Байгаль орчны хамгаалал, усан мандал Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага
Чанарын үзүүлэлт, цэвэршилт	ЦБ-ын гаралтын хаягдал ус ЦБ -ын оролтын хаягдал ус	Улирал бүр	2 цэгт 4 удаа	90.0 төг*4удаа*2цэг	720.0	
Нийт зардал мян. төг					13 680.0	



Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг хийхдээ “Ашид Ананда” ХХК-ний экспертүүд Төв аймгийн Зуунмод суманд үйл ажиллагаа явуулж буй “Төвчандмань дэхг” ОНӨААТҮГ-ын “Ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн байгууламжуудын талбайд 2023 оны 06-р сарын 06-ний болон 2023 оны 10-р сарын 16-ний өдрүүдэд хийсэн хээрийн судалгааны үр дүнд үндэслэн энэхүү тайланг хийж гүйцэтгэв.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд агаар, хөрсөн бүрхэвчинд хяналт шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

1. Хөрсний хяналт шинжилгээ

Судалгааны зорилго: Хөрсний доройтол, бохирдол, төрөл зэрэглэлийг тогтоож хяналт шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорьсон. Төслийн талбайд тархсан хөрсөн бүрхэвчийн хээрийн болон суурин судалгааны үр дүнд тулгуурлан гүйцэтгэв.

Судалгааны аргазүй, дээж авалт

Хээрийн судалгааны арга зүй: Хээрийн судалгаагаар судалгааны талбайтай танилцах, хөрсний төлөөлөл болохуйц цэг сонгох, GPS-ийн хэмжилт авах, хөрсний дээж авах зэрэг үйлдлийг гүйцэтгэсэн.

Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн хээрийн судалгааг 2023 оны 06-р сарын 06-ний өдөр гүйцэтгэв. Нийт 18 цэгээс хөрсний дээж авч, хөрсний агрохимийн 6 дээжийг 200-300 гр, хүнд металлын 15 дээжийг 200-300 гр хэмжээтэй авсан. Мөн хөрсний эрүүл ахуйн 15 дээжийг 100 гр хэмжээтэй авсан. Зүсэлт хийсэн цэгийн газарзүйн байршлыг байршил тогтоогч GPS багажаар тэмдэглэсэн.

Зураглалын арга зүй: Судалгааны талбайгаас авсан мэдээлэл агаар сансрын зургийн мэдээлэлд үндэслэн хөрсний дээж авсан газрын зураглал, хөрсөн бүрхэвчийн зураглалыг үйлдлээ. Тухайлбал хөрсний гадаргын төрх байдлын тодорхойлолт, хөрсний (морфологи шинж) бичиглэл хийж, хөрсийг ангилан, улмаар талбайн хүрээнд тархсан хөрс, гадаргын 1:100 000 масштабтай зураг зохиож, түүн дээр хөрсний дээж авсан цэгүүд буюу зүсэлт хийсэн цэгүүдийн байршлыг тэмдэглэв.

Задлан шинжилгээний арга зүй: Хөрсний агрохими, хүнд металл болон хөрсний эрүүл ахуйн дээжийг “Нарт Шуун Консалтинг” ХХК-ийн хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.

Боловсруулалт: Хээрийн судалгааны ажлын үед хийсэн хөрсний морфологи шинж чанарын бичиглэл болон агрохимийн үзүүлэлтүүд, механик бүрэлдэхүүний лабораторийн шинжилгээний үр дүнг хэвшинж тус бүрээр үр дүнгийн хэсэгт үзүүлж, дэлгэрэнгүй тайлбар хийсэн. Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлсон.

Судалгааны үр дүн

Төсөл хэрэгжих талбай нь газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллаар Төв аймгийн Зуунмод хотын нутаг дэвсгэрт хамаарна. Төслийн районд хар хүрэн хөрс тархсан бөгөөд барилга байгууламжийн нөлөөгөөр хөрсөн бүрхэвч талхлагдаж, үндсэн хэв шинжээ алдсан.



Зүсэлт №1



Хүснэгт 6. Төслийн талбайн 1-р зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл

Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар	Зүсэлт №1	
Байршил	Төв аймгийн Зуунмод хот, Хөшигтийн хандийн эх үүсвэр	
Өндөр	д.т.д 1225.5 метр	
Газрын гадарга	1.6°C	
Ургамлын бүрхэвч	35%	
Хөрсний нэр	Хар хүрэн хөрс	
Хөрсний фото	Гүн	
	А. 0 -10 10 см	Хар хүрэн өнгөтэй, том чулуурхаг, сийрэг, элсэнцэр механик бүтэцтэй.
	В. 15 -40 25 см	Цайвар хүрэн өнгөтэй, чулаархаг, сийрэг,

Хүснэгт 7. Төслийн талбайн 1-р зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт

Зүсэлт дугаар	Гүн, см	pH H ₂ O	ЦДЧ, dS/m	Давс, %	Ялзм аг %	CaCO ₃	NO ₃ , мг/100г	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
								Ca ⁺²	Mg ⁺²	P ₂ O ₅	K ₂ O
1	0-10	7.55	0.067	0.027	2.74	0.0	0.51	15	5	3.9	22
	10-40	8.26	0.095	0.039	0.76	1.6	0.37	17	11	4.5	17

Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь дунд зэргийн шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж өнгөн үедээ сайн бөгөөд үе давхарга доошлох тусам буурсан, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфорын хангамж бага, хөдөлгөөнт калийн хангамж дунд зэрэг байна. Солилцох сууриудын нийлбэр 20-28 мг хэвийн хангамжтай байна. Карбонат өнгөн үедээ илрээгүй, азотын агууламж бага зэрэг илэрсэн.

Зүсэлт №2



Хүснэгт 8. Төслийн талбайн 2-р зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл

Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар	Зүсэлт №2	
Байршил	Төв аймгийн Зуунмод хот, Цэвэрлэх байгууламж	
Өндөр	д.т.д 1270.0 метр	
Газрын гадарга	0.7 °C	
Ургамлын бүрхэвч	25%	
Хөрсний нэр	Хар хүрэн хөрс	
Хөрсний фото	Гүн	
	A. 0 -10 10 см	Хүрэн өнгөтэй, үүрмэг чулуурхаг, сийрэг бүтэцтэй
	B. 10 -20 10 см	Хар аүрэн өнгөтэй, том чулуурхаг, бөөмөн бүтэцтэй.

Хүснэгт 9. Төслийн талбайн 2-р зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт

Зүсэлт дугаар	Гүн, см	pH H ₂ O	ЦДЧ, dS/m	Давс, %	Ялзм аг %	CaCO ₃	NO ₃ , мг/100г	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
								Ca ⁺²	Mg ⁺²	P ₂ O ₅	K ₂ O
2	0-10	7.93	0.022	0.009	2.46	0.00	0.16	16	4	4.4	12
	10-20	9.66	0.034	0.014	3.78	0.00	0.22	19	14	4.5	13

Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж сайн, карбонат илрээгүй байна. Шингээгдсэн сууриудын нийлбэр хэмжээ хэвийн, хялбар уусах давсны агууламж бага буюу давсжилтгүй байна. Хөдөлгөөнт фосфорын хангамж бага, хөдөлгөөнт калийн хангамж дундаас бага зэрэг хангамжтай байна.

Зүсэлт №3



Хүснэгт 10. Төслийн талбайн 3-р зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл

Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар	Зүсэлт №3	
Байршил	Төв аймаг Зуунмод хот, Насос станц 1	
Өндөр	д.т.д 1260.7 метр	
Газрын гадарга	0.2 °C	
Ургамлын бүрхэвч	20%	
Хөрсний нэр	Хар хүрэн хөрс	
Хөрсний фото	Гүн	
	А. 0 -20 20 см	Хар хүрэн өнгөтэй, жижиг чулуурхаг, ургамалын үндэс багатай.
	В. 20 -50 30 см	Хар хүрэн өнгөтэй, жижиг чулуурхаг, элэнцэр механик бүрэлдэхүүнтэй.

Хүснэгт 11. Төслийн талбайн 3-р зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт

Зүсэлт дугаар	Гүн, см	pH H ₂ O	ЦДЧ, dS/m	Давс, %	Ялзм аг %	CaCO ₃	NO ₃ , мг/100 г	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
								Ca ⁺²	Mg ⁺²	P ₂ O ₅	K ₂ O
3	0-20	8.57	0.061	0.025	3.65	0.0	0.22	25	12	3.9	10
	20-50	8.46	0.059	0.024	1.86	0.0	0.37	14	8	4.7	18

Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь дунд зэрэг шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж сайн үе даюхарга доошлох тусам буурсан, карбонат илрээгүй байна. Шингээгдсэн сууриудын нийлбэр хэмжээ хангамжтай, хялбар уусах давсны агууламж бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфорын хангамж бага хөдөлгөөнт калийн хангамж дунд зэрэг байна.

Хөрсний механик бүрэлдэхүүн

Хөрсний хатуу хэсгийг бүрдүүлж байгаа жижиг ширхгүүдийн хэмжээгээр нь ангилан тэдгээрийг хувиар илэрхийлснийг механик бүрэлдэхүүн гэнэ. Энгийн ширхгийн хэмжээгээр нь шороо ба чулуу гэсэн хоёр том бүлэгт хуваана. Хөрсний задлан шинжилгээнд бэлтгэхэд 1 мм-ийн шигшүүрээр шигших бөгөөд түүнээс том хэмжээтэйг чулуу, харин шигшигдэж орсон 1 мм-ээс бага ширхэгтэйг шороо гэнэ (Аваадорж бусад 2012).

Хүснэгт 12. Хөрсний механик бүрэлдэхүүн

Зүсэлт №	Гүн, см	Механик ширхэгүүд (%), ширхэгийн хэмжээ (мм)						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	0-10	15.6	55.9	13.5	5.4	5.7	3.9	15.0
	10-40	14.3	55.6	10.6	6.5	5.1	7.9	19.5
2	0-10	52.1	28.1	10.0	1.4	5.1	3.3	9.8
	10-20	42.2	32.9	10.3	3.1	6.2	5.3	14.5
3	0-20	22.8	43.7	13.7	1.5	15.0	3.2	19.8
	20-50	55.4	26.3	7.4	4.8	3.1	3.1	10.9

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох хоёр дахь арга Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

Хөрсний бохирдол

Төслийн талбай нь хөрсний бохирдолтыг тодорхойлох зорилгоор 15 цэгт хөрсний дээж авч, хүнд металлын 15 дээжийг 200-300 гр хэмжээтэй хөрсний дээж авч лабораторид шинжлүүлсэн. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu, гэсэн 6 элементийн хөрсний бохирдолтыг үзүүллээ.

Хүснэгт 13. Хөрсөн дэх хүнд металлын үзүүлэлтүүд, 2020 он

Дугаар	Дээж авсан гүн, см	Хүнд металлын агууламж мг/кг					
		Ni никель	Cd кадмий	Pb /Хар тугалга/	Zn /цайр/	Cr /хром/	Cu /зэс/
Цэвэрлэх байгууламж	0-10	10.9	0.0	41.7	55.9	14.3	15.6
Ус түгээх цэг	0-10	4.3	0.0	41.7	14.8	28.6	14.6
Халаалт-2	0-10	2.6	0.0	37.5	37.9	28.6	13.5
Халаалт-3	0-10	2.2	0.0	39.6	26.8	14.3	13.5
Ус түгээх цэг-3	0-10	4.8	0.0	43.8	39.4	42.9	18.3
Халаалт-5	0-10	3.0	0.0	43.8	33.2	42.9	15.9
Халаалт-1	0-10	6.9	0.0	45.9	44.7	57.2	22.7
Ус түгээх цэг-19	0-10	8.1	0.0	54.2	47.1	71.5	24.3
Ус түгээх цэг-15	0-10	6.1	0.0	47.9	4.6	57.2	186
Ус түгээх цэг-12	0-10	4.8	0.0	45.9	22.8	71.5	24.3
Ус түгээх цэг-13	0-10	2.6	0.0	56.3	22.8	71.5	22.3
Ус түгээх цэг-20	0-10	3.9	0.0	50.0	31.3	71.5	22.0
Ус түгээх цэг-2	0-10	9.1	0.0	47.9	38.2	71.5	21.3
Ус түгээх цэг-1	0-10	3.0	0.0	47.9	54.6	57.2	17.6
Ус түгээх цэг-9	0-10	7.4	0.0	43.8	51.7	57.2	23.0
Хүлцэх агууламж /MNS5850:2019/	Элсэрхэг хөрс	60.0	1.0	50.0	100.0	60.0	60.0
	Шавранцар хөрс	100.0	1.5	70.0	150.0	100.0	80.0
	Шаварлаг хөрс	150.0	3	100.0	300.0	150.0	150.0

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” (MNS 5850:2019)-



ийн стандарттай харьцуулахад элсэнцэр хөрсөнд агуулагдах зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс Ус түгээх цэг-13 ойролцооноос авсан хөрсний дээжинд хар тугалгын агууламж 6.3 мг-иар их, Ус түгээх цэг-19, 12, 13, 20, 2 ойролцооноос авсан хөрсний дээжинд хром агууламж 11.5 мг-иар их гарсан. Бусад дээжнүүдэд элсэнцэр хөрсөнд агуулагдах зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс доогуур буюу хөрс бохирдолгүй байна.

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ

Хүснэгт 14. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ

Дээжний дугаар	Нянгийн тоо MNS 6341:2012	Гэдэсний савханцрын титр MNS 5367:2004		Перфрингенсийн таньц MNS 6341:2012	
	Шинжилгээ хариу	Шинжилгээ хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээ хариу	Бохирдлын зэрэг
Цэвэрлэх байгууламж	1.9*10 ⁵	1	1	0.1<	1
Ус түгээх цэг	4.4*10 ⁵	1	1	0.1<	1
Халаалт-2	1.6*10 ⁵	1	1	0.1<	1
Халаалт-3	2.1*10 ⁵	1	1	0.1<	1
Ус түгээх цэг-3	3.6*10 ⁵	1	1	0.1<	1
Халаалт-5	3.0*10 ⁵	1	1	0.1<	1
Халаалт-1	2.1*10 ⁵	1	1	0.1<	1
Ус түгээх цэг-19	4.2*10 ⁵	1	1	0.1<	1
Ус түгээх цэг-15	2.9*10 ⁵	1	1	0.1<	1
Ус түгээх цэг-12	4.5*10 ⁵	1	1	0.1<	1
Ус түгээх цэг-13	3.7*10 ⁵	1	1	0.1<	1
Ус түгээх цэг-20	5.0*10 ⁵	1	1	0.1<	1
Ус түгээх цэг-2	3.1*10 ⁵	1	1	0.1<	1
Ус түгээх цэг-1	5.8*10 ⁵	1	1	0.1<	1
Ус түгээх цэг-9	4.1*10 ⁵	1	1	0.1<	1

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үр дүнг (MNS 3297-2019) Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарттай харьцуулахад дээрх үзүүлэлт илрээгүй буюу хөрс бохирдолгүй байна.

Дээж -1 (Цэвэрлэх байгууламж)



Дээж -2 (Ус түгээх цэг)



Дээж -3 (Халаалт-2)

Дээж -4 (Халаалт-3)



Дээж -5 (Ус түгээх цэг-3)



Дээж -6 (Халаалт-5)



Дээж -7 (Халаалт-1)



Дээж -8 (Ус түгээх цэг-19)



Дээж -9 (Ус түгээх цэг-15)



Дээж -10 (Ус түгээх цэг-12)



Дээж -11 (Ус түгээх цэг-13)



Дээж -12 (Ус түгээх цэг-20)



Дээж -13 (Ус түгээх цэг-2)



Дээж -14 (Ус түгээх цэг-1)



ТӨВЧАНДМАНЬ ДЭХГ
ТӨВ АЙМАГ
ДЭЭН-13
УС ТҮГЭЭХ-1
2023.06.03



Дээж -15 (Ус түгээх цэг-9)



Зураг 6. Хөрсний дээж авсан цэгүүдийн зураг

2. Усны шинжилгээ

Судалгааны арга зүй

Хээрийн судалгааны арга зүй: Хээрийн судалгааны хүснэгтэд дараах мэдээллүүдийг тэмдэглэв. Үүнд:

- Бичиглэл хийсэн он, сар өдөр;
- Хэмжилт, дээжлэлт хийсэн солбицол (WGS 1984 UTM Zone 48N);

Хээрийн судалгааны үед дээж авах даа MNS 5667-11:2000 (Гүний уснаас дээж авах зөвлөмж) стандартыг баримтлан ажилласан. Дээжлэлтийг хийхдээ эхлээд тусгай зориулалтын палиэтилен дээжний саваа 3 удаа тухайн дээжлэлт хийх гэж байгаа усаар зайлна. Үүний дараа дээжний саваа дээжээр бүрэн дүүргэж дээр нь агаар байх зайгүйгээр таглана. Ингэснээр тээвэрлэлтийн үед сэгсрэгдэх, хийнүүдийн хоорондох харилцан үйлчлэлийг хязгаарлана. Тээвэрлэлтийн үед дээжүүдийг харанхуй, сэрүүн хайрцагт хадгалсан.

Цэвэр ус хангамжийн эх үүсвэр, дамжуулах станц, өндрийн сан, ус түгээх байр зэрэг хэрэглэгчдэд түгээж буй цэвэр усны нийт 20 цэгээс дээж авсан. Мөн хаягдал усны оролт, гаралт тус бүр 1 дээж авсан.

Задлан шинжилгээний арга зүй: Хаягдал усны хүнд металл болон эрүүл ахуйн дээжийг “Нарт Шуун Консалтинг” ХХК-ийн хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Цэвэр усны хими болон эрүүл ахуйн үзүүлэлтийг Төв аймгийн Эрүүл Мэндийн Газрын лабораторид шинжлүүлсэн.

Судалгааны үр дүн



Зураг 7. Уснаас дээж авч буй байдал

Бохир ус:

Бохир уснаас авсан 2 дээжийг авч (орох хэсэг, гарах хэсэг) бохир усан дахь бохирдуулах зарим металлын шинжилгээ болон жинлэгдэх бодис, pH, химийн хэрэгцээт хүчилтөрөгч, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, нийт азотын шинжилгээг “Нарт Шуун Консалтинг” ХХК-ийн хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.

Усны шинжилгээний үр дүнг MNS 4943:2015 (Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага), MNS6561:2015 (Хүрээлэн байгаа орчин. Усны чанар.

Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага) стандарттай тус тус харьцуулсан.

Хүснэгт 15. Бохир усны шинжилгээ

Элемент нэгдэл	Хэмжих нэгж	MNS 4943:2015 мг/л	MNS 6561 : 2015 мг/л	Бохир ус орох хэсэг	Бохир ус гарах хэсэг
Металлууд					
Хром (Cr)	мг/л	0.3	1.0	0.00	0.00
Зэс (Cu)	мг/л	1	1.0	0.027	0.054
Хартугалга (Pb)	мг/л	0.1	0.2	0.042	0.208
Никель (Ni)	мг/л	0.2	0.5	0.009	0.14
Цайр (Zn)	мг/л	3	5.0	0.045	0.00
Химийн бодисын зарим үзүүлэлтүүд					
Хлорид (Cl)	мг/л	-	1000	70.6	52.6
Нитрат (NO ₃)	мг/л	-	-	151	132
Сульфат (SO ₄)	мг/л	-	700	138.9	78
pH	-	6-9	6-9	8.34	8.36
Жинлэгдэх бодис	мг/л	30	400	16	5
химийн хэрэгцээт хүчилтөрөгч	мгО/л	50	400	-	
биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	мгО/л	20	800	26	8
Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч	1 мг	илрэхгүй	-	илэрсэн	илрээгүй

Бохир усан (орох хэсэг, гарах хэсэг) дахь зарим хүнд металлын агууламжийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж үр дүнг MNS 4943:2015 (Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага), MNS6561:2015 (Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага) тус тус стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна. Бохир ус орох хэсгээс авсан дээжинд гэдэсний бүлгийн эмгэг төрөгч илэрсэн байна.

Цэвэр усны чанар:

Цэвэр ус хангамжийн эх үүсвэр, дамжуулах станц, өндрийн сан, ус түгээх байрнуудаас авсан нийт 12 дээжинд усны ерөнхий химийн шинжилгээ, усны эрүүл ахуйн үзүүлэлтийг Төв аймгийн Эрүүл Мэндийн Газрын лабораторид шинжлүүлсэн.

Усны шинжилгээний үр дүнг MNS 0900:2018 (Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ" стандарттай харьцуулсан.

Насос стац-1 болон УТБ-6 хэсгээс авсан 2 усны дээжний химийн ерөнхий шинжилгээний дүн.

Хүснэгт 16. Цэвэр усны химийн ерөнхий шинжилгээ

№	Химийн шинжилгээний үзүүлэлтүүд	Насос стац-1	УТБ-6	MNS 0900: 2018, мг/л
1	Усан орчны (pH)	7.2	7.2	6.5-8.5
2	Cl ⁻	0.0	0.0	350.0
3	SO ₄ ²⁻	-	-	500.0
4	NO ₂ ⁻	0.9	0.02	1.0
5	NO ₃ ⁻	0.0	0.0	50.0
6	Ca ⁺⁺	32	32	100.0



№	Химийн шинжилгээний үзүүлэлтүүд	Насос станц-1	УТБ-6	MNS 0900: 2018, мг/л
7	Mg ⁺⁺	-	-	30.0
8	Fe ⁺⁺	0.0	0.0	0.3
9	Хуурай үлдэгдэл	280	289	0.5-1000
10	Хатуулаг	3.3	3.2	7.0
11	Аммоний NH ₄ ⁺	1.5	0.0	0.5

Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандарт (MNS 0900:2018)” шаардлага хангаж байна.

Цэвэр ус хангамжийн эх үүсвэр, насос станц, өндрийн сан. ус түгээх байрнаас авсан цэвэр усны 10 дээжний усны бичил амь судлалын шинжилгээний дүн

Хүснэгт 17. Цэвэр усны бичил амь судлалын шинжилгээ

№	Дээж авсан байршил	Нянгийн тоо, тоо/1мл	E.Coli, тоо/ мл	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян, тоо/ мл
1	Насос станц-1	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
2	УТБ-6	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
3	Өндрийн сан	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
4	УТБ-19	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
5	3-р өргөх	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
6	1-р өргөх	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
7	Гүний 2	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
8	Гүний 5	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
9	3076	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
10	Эх үүсвэр	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
MNS 0900: 2018, тоо/мл		<100	илрэхгүй	илрэхгүй

Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандарт (MNS 0900:2018)” шаардлага хангаж байна.

“Төвчандмань ДЭХГ” ОНӨААТҮГ нь цэвэр ус хангамжийн эх үүсвэр, дамжуулах станц, өндрийн сан, ус түгээх байр зэрэг хэрэглэгчдэд түгээж буй цэвэр усны чанар, аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж, аймгийн Эрүүл Мэндийн Газрын лабораторит сард 1 удаа хими болон эрүүл ахуйн үзүүлэлтээр шинжилгээний хийлгэдэг. Цэвэр усны эрүүл ахуйн микробиологийн үзүүлэлт болон цэвэр усны химийн үзүүлэлтийн лабораторийн шинжилгээний дүнг хавсралтаар хавсаргав.

3. Агаарын тоосжилтын хяналт, шинжилгээ

